



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 08 өдөр

Дугаар Б/38

Хэрлэн сум

Төлөөлөн удирдах зөвлөлөөс
чөлөөлөх тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, 11.1.3, Эмнэлгийн тусламжийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.30, 15.10.4, 15.10.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Нэгдсэн эмнэлгийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хамт олны эмнэлгийн мэргэжилтнээс бусад ажилтны төлөөлөл Д.Урансайхан нь өөр ажилд шилжсэн, олон нийтийн төлөөллийн Даатгуулагчийн олонхын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалсан байгууллагын төлөөллөөр сонгогдсон Д.Алтангэрэл нь ашиг сонирхлын зөрчилтэй гэж холбогдох байгууллагаас дүгнэсэн тул аймгийн Нэгдсэн эмнэлгийн Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнээс тус тус чөлөөлсүгэй.

2. Нөхөн сонгох үйл ажиллагааг зохион байгуулах хүртэл Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг хэвийн явуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга (Б.Дарханбаатар)-д үүрэг болгосугай.

3. Холбогдох хууль, журмын дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг нөхөн сонгох үйл ажиллагааг зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн даргыг үүргийг түр орлон гүйцэтгэгч (Н.Зоригтбаатар)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ